



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА

Лагшан төв, С.Амарын гудамж, Ерөнхий сайд, 8 дугаар
хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 14 89, 26 14 90, Факс: (976-11)-31 06 42
Цахим шуудан: info@monmarad.gov.mn
Цахим хуудас: www.monmarad.gov.mn

2025.12.15 № 01/517
танай _____-ны № _____-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.НАСАНТОГТОХ ТАНАА

Монгол Улсын Далайн захиргааны
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон
тооны бус зөвлөлийн Хөдөлмөрийн аюулгүй
байдал, эрүүл ахуйн 3 дугаар шатны үзлэгийг
зохион байгуулсан ажлын тайланг хавсралтаар
хүргүүлж байна.

Хавсралт 9. хуудастай.



МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА

МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА

1425041332



МОНГОЛ УЛСЫН
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
3 дугаар шатны хяналт зохион байгуулах
комисс томилох тухай

Монгол Улсын Далайн захиргааны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг, Монгол Улсын Далайн захиргааны даргын 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 68 дугаар тушаалын хавсралт "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтыг зохион байгуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3, 1.5 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 3 дугаар шатны хяналтыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгон болон Ханх сум, Архангай аймгийн Өгийнуур сум дахь усан замын тээврийн "Хяналтын пост"-уудад зохион байгуулах үүрэг бүхий Комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Номин.
Гишүүн:	Усан замын тээврийн бүртгэл, хяналтын албаны ахлах мэргэжилтэн Ш.Долгион.
Нарийн бичгийн дарга:	Тайлан, төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэн (ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн нарийн бичгийн дарга) Б.Батчимэг.

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гуравдугаар шатны хяналтыг зохих журмын дагуу зохион байгуулах, үр дүнг удирдлагад танилцуулах, илэрсэн дутагдлыг арилгуулах талаар авах арга хэмжээний санал боловсруулахыг Комисс (Б.Номин)-т даалгасугай.

ДАРГА



М.ӨЛЗИЙ

00000539

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН 3-Р ШАТНЫ ҮЗЛЭГЭЭР АЖИЛЛАСАН ТОМИЛОЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Нэг. Ажлын зорилго

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03/2813 дугаартай “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” албан бичиг, “Монгол Улсын Далайн захиргааны хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ын хэрэгжилтийг хангах, Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум, Архангай аймгийн Өгийнуур сум дахь усан замын тээврийн хяналтын постын байр, хашаа, харуулын байр, аврах завь, завины өвлийн битүү зогсоолын байр зэрэг объектуудад үзлэг шалгалт хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/155 дугаар тушаалаар томилогдсон комиссын гишүүд Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх, Архангай аймгийн Өгийнуур сумдад ажилласан болно.

Хоёр. Томилолтын хугацаа

Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум, Архангай аймгийн Өгийнуур зэрэгт 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд.

Гурав. Томилолтоор ажилласан бүрэлдэхүүн

Монгол Улсын Далайн захиргааны Захиргаа, удирдлагын хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын ахлах мэргэжилтэн Б.Номин, Усан замын тээврийн бүртгэл, хяналтын ахлах мэргэжилтэн Ш.Долгион, Тайлан, төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэн /ХАБЭА орон тооны бус зөвлөлийн нарийн бичгийн дарга/ Б.Батчимэг, Далайн тээвэр, хуурай боомтын хэлтсийн эдийн засаг, статистикийн мэргэжилтэн Д.Отгонбаяр, Нярав Ш.Нарангэрэл, Жолооч Ч.Хангай нарын бүрэлдэхүүнтэй.

Дөрөв. Томилолтын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил

Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын тээврийн “Хяналтын пост” болон бусад байгууламжуудад хийсэн үзлэг шалгалтаар хэд хэдэн дутагдал илэрсэн. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь хяналтын пост /гэрэлт цамхаг/-ын оффисын зориулалтаар ашиглаж байгаа өрөө нь өвлийн улиралд халаалт байхгүй доод давхарт гал түлсэн үед яндангийн дулаанаар халдаг ба яндангийн битүүмж алдагдаж борооны улмаас зэвэнд идэгдэж цоорсон, бороотой үед яндан дагаж дусаал гоождог, цахилгааны дотор монтаж масстай, шатны хаалт хөдөлгөөнтэй, камерын систем ажиллагаагүй, ХАБЭА-н болон мэдээллийн самбар байршуулаагүй, цахилгаан тасарсан үед нөөц гэрэлтүүлэг байхгүй, гал унтраах хэрэгслийн ашиглалт ажиллагаа хангалтгүй, өрөөний эмх цэгц муу зэрэг зөрчил дутагдал илэрлээ.

- Амралтын өрөөнд халаалтын систем огт ажиллагаагүй, гал тогооны өрөөний галаар бага зэрэг халдаг, шал, хананаас дулаан алддаг, дотор цахилгааны монтаж масстай.
- Газын плитка болон баллонтой газны хадгалалт хэрэглээ галын аюул үүсэх эрсдэлтэй.
- Гал тогооны хэсэгт зуух, яндан шаардлага хангахгүй, зуух дулаан барихгүй хурдан халж хөрдөг, яндангийн битүүмж алдагдсанаас утаа гардаг нь гал алдах угаартах эрсдэлтэй, цахилгааны дотор монтаж масстай, дотор гэрлүүд маш бүдэг, агааржуулалтын хоолойгүйн улмаас хоол унд хийхэд уур их гарч цан цохидог, гал унтраах хэрэгсэл хангалтгүй зориулалтын бус, тавилга эд хогшлын ашиглалтын хугацаа дууссан, өрөөний зохион байгуулалт зай талбай маш муутай байна.
- Гражийн халаалтын систем ажиллагаагүй дотор гэрлүүд зарим нь шатсан, камерын системгүй, эд хогшлын ашиглалт, хамгаалалт муутай, хугацаа нь дууссан аврах хантаазнууд болон тэсэрч дэлбэрэх бодис хадгалдаг савыг ихээр хамтад нь хураасан, хувь айлын эд хогшил хамт хадгалж байсан, гражийн эргэн тойрон борооны усны зайлуулагчгүйн улмаас граж усанд автах эрсдэлтэй зэрэг дутагдал илэрлээ.
- Өвлийн битүү зогсоол /ангар/ цэвдэгийн улмаас суулт өгч шаланд ан цав үүссэн, шалны будаг арилсан, хальтиргаа үүсэх магадлалтай, нөөц гэрэлтүүлэг хангалтгүй, ХАБЭА-н зааварчилгааны самбарын ашиглалт муу, гал унтраах хэрэгслийн ашиглалт шаардлага хангахгүй, утаа мэдрэгч ажиллагаагүй, өөр байгууллагын эд хогшил хамт хадгалсан, SAR тусгай зориулалтын завины сэлбэг хэрэгслийг эмх замбараагүй хураасан, завин дээрх аврах хантаазны бүрэн бүтэн байдал, тоо хэмжээ дутагдалтай, ослын үеийн дохионы хэрэгсэл байхгүй, тусгай зориулалтын завины олс хангалтгүй, эмийн сангийн доторх хэрэгслийн хугацаа дууссан, чанга яригчийг завины дотор байршуулаагүй, батерейгүй зэрэг бэлэн байдал хангалтгүй, зайлшгүй арга хэмжээ авах шаардлагатай.
- Ангарын гадна эргэн тойронд хөрсний нуралтаас хамгаалсан зориулалтын эко хаалт мөн эргэн тойрон хашлага хийж хүн унаж бэртэхээс сэргийлэх, явган хүний зам байхгүйн улмаас цас бороотой үед хальтирч унах эрсдэлтэй, авто зогсоолын хэсэг байхгүй тул тээврийн хэрэгслийг дуртай газраа байрлуулж хөрсний элэгдэл үүссэн.
- Байгууллагын хашааны гадна байрлах цахилгааны шугамын 2 шон сууриараа хазайсан байсныг засаж, аюулгүй байдлыг хангасан хэдий ч олон хэрэглэгчтэй, зөвшөөрөлгүй байгууллагын цахилгаан ашигладаг, эрчим хүч ашигласны төлбөрийг төлдөггүй, цаашдаа дахиж хазайх эрсдлээс урьдчилан сэргийлж хашлага, хаалт хийлгэх шаардлагатай;
- Хяналтын байр хүйтний улиралд халаалт муу, амралтын жижиг өрөөнүүд маш хүйтэн бөгөөд байнгын гал түлэх шаардлага үүсдэг байна. Тус дулааны асуудлыг гүйцэтгэгч компанитай хэлэлцэж шийдвэрлэх.

- Усан замын тээврийн хяналтын байранд байрлуулсан орны матрассны эдэлгээ муудсан, эвдрэл үүссэн байгаа нь амрах ая тухтай байдалд нөлөөлөх бөгөөд шинээр солих шаардлагатай.
- Оффисын зориулалтаар ашиглаж буй өрөө хөшиггүй, тавилга, техник хэрэгслүүд нь муудсан, эвдэрсэн байсан учир шинээр солих эсхүл элэгдэл багатай тавилга, техник хэрэгслээр сэлбэж байршуулах.

Хөвсгөл аймгийн Ханх сум дахь усан замын тээврийн “Хяналтын пост” болон бусад байгууламжуудад хийсэн үзлэг шалгалт хийснээр дараах дутагдлуудыг илрүүллээ. Үүнд:

- Бүтээн байгуулалтын ажил хийгдсэнээс хойш тохижилтын ажил хийгдсэн гэвч халаалтын систем бүрэн ажиллагаагүй, байрны цонх хаалганы дулаан алдалт ихтэй, дотор цахилгааны монтаж буруу хийсэн, гадна гэрэлтүүлэг, нөөц гэрэлтүүлэг байхгүй, ХАБЭА-н зааварчилгааны санамж самбар байхгүй, мэдээллийн самбар, хаягжилт болон төрийн далбаа байхгүй, галын сарааны бүрэн бүтэн байдал хангалтгүй, камерын систем байхгүй, ажилтны хөдөлмөрийн багаж хэрэгсэл хангалтгүй, ХАБЭА-н зааварчилгааны дэвтэр хөтөлдөггүй, ХАБ-ын сургалтад хамрагдаагүй зэрэг дутагдал илэрлээ.

Архангай аймгийн Өгийнуур сум дахь усан замын тээврийн “Хяналтын пост” болон бусад байгууламжуудад хийсэн үзлэг шалгалтаар:

- Шинээр бүтээн байгуулалтын ажил хийсэн ба террасны эргэн тойронд хаалт хашлага байхгүй;
- Гадна гэрэлтүүлэг муутай, цонхнуудад хаалт байхгүй, лого бүхий хаягжилт, хашааны хаалгануудад цоож цуургатай болгох зэрэг дутагдлыг арилгах;
- Оффисын өрөө болон ариун цэврийн өрөөг хооронд нь тусгаарласан хаалга суурилуулах;
- Төв оффисоос явуулсан тавилгуудыг бүрэн угсарч ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах;
- Тусгай зориулалтын завин дээрх аврах хантаазны бүрэн бүтэн байдал, тоо хэмжээ дутагдалтай, ослын үеийн дохионы хэрэгсэл байхгүй, тусгай зориулалтын завины олс хангалтгүй, эмийн сангүй, чанга яригч ажиллагаагүй зэрэг бэлэн байдал хангалтгүй байгааг анхаарах;

Тав. Дүгнэлт, санал

- Томилолтоор ажиллах хугацаанд илэрсэн дээрх дутагдлуудыг арилгах талаар хариуцсан нэгжийн удирдлага болон мэргэжилтнүүдэд үүрэг өгөх, шаардлагатай төсөв зардлыг байгууллагын төсөвт тусган шийдвэрлүүлэх;
- Барилгын гүйцэтгэгч компанитай холбогдож, чанарын шаардлага хангахгүй байгаа ажлуудыг засуулах арга хэмжээ авах;
- Хөвөлтийн улирал эхлэхээс өмнө томилолтоор ажиллах албан хаагчид, улсын байцаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах;

- засаж сайжруулах, шаардлагатай зардлыг ирэх оны төсөвт тусгах;
- Галын аюулгүй байдлыг сайжруулж зуух, янданг шинээр солих, оч баригч хийх, гал унтраах хэрэгсэл, галын сарааны бүрэн бүтэн байдлыг хангах;
 - Гадна орчны аюулгүй байдлыг ханган хайс, хашлага, хөрсний нуралтаас сэргийлсэн тор, явган зам, борооны усны суваг шуудуу татах;
 - Тээврийн хэрэгслийн тэмдэг, тэмдэглэгээ бүхий авто машины зогсоолыг нэгдсэн байдлаар шийдэх;
 - Газрын кадастрын зургийн дагуу газар дээр нь мэргэжлийн байгууллагаар цэг хатгуулж, хашааны хэмжээг дахин тодорхойлуулах;
 - Бохир зайлуулах ААН-тэй гэрээний хэрэгжилтэд хяналт тавих талаар холбогдох мэргэжилтэнтэй байгуулах гэрээнд тусгах;
 - Орон нутгийн байгууллагатай хог, хаягдлын гэрээ байгуулах, тэмдэглэл хөтөлдөг байх;
 - Орон нутгийн онцгой байдлын газраар галын дүгнэлт гаргуулах;
 - Гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй болох;
 - ХАБЭА-н хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зааварчилгааны санамж, самбар, ХАБ зааварчилгааг өгөх ажлыг тогтмолжуулж, зааварчилгааны дэвтэр хөтлөлтийг сайжруулах;

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 3 дахь шатны үзлэгээр ажиллах үед баталгаажуулж дарсан фото зураг хавсаргав.

ТАНИЛЦСАН:

МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА



М.ӨЛЗИЙ


ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Т.МӨНХБАЯР

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН
АЛБАНЫ ДАРГА (ХАБЭА ОРОН ТООНЫ
БУС ЗӨВЛӨЛИЙН ДАРГА)



Т.ОЛОНБАЯР


ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД
АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.НОМИН

ТАЙЛАН БИЧСЭН:

ТАЙЛАН ТӨЛӨВЛӨГӨӨ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН,
(ХАБЭА-Н ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА)



Б.БАТЧИМЭГ

УСАН ЗАМЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
(ГАМШГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН,
ШТАБЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА)



Ш.ДОЛГИОН



